

# Монголын Материал Судлал Гагнуурын Нийгэмлэгийн 2020 онд хийсэн ажлын тайлан

Нэг. ММСГНийгэмлэгээс тайлангийн хугацаанд хийж хэрэгжүүлсэн ажлын талаар

А. Зохион байгуулалт, сурталчилгааны чиглэлээр

1. Нийгэмлэгийн зүгээс 2020 онд хийх ажлын төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллаа.
2. ММСГНийгэмлэгийн үндсэн зорилт үйл ажиллагаа болон цаашид хэрэгжүүлэх ажлын талаар төрийн байгууллагууд, ААН, хувь хүмүүст сурталчлан танилцуулах ажлыг байнга зохион байгуулж ажиллав. Тайлант онд нийгэмлэгийн гүйцэтгэх захирал, удирдлага Эрчим хүчний сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд нартай хийсэн уулзалтуудад оролцож нийгэмлэгийн үйл ажиллагаа, зорилгоос тодорхой танилцуулсан. Нийгэмлэгийн [www.mmsws.mn](http://www.mmsws.mn) веб сайтад үйл ажиллагаагаа танилцуулж ирлээ.
3. Нийгэмлэгт хандаж ажил төрлийн холбоо, тогтоох зөвөлгөө авах, сургалтад хамруулах зэрэг асуудлаар хандсан байгууллага, хувь хүмүүстэй уулзаж тус дэм болох чиглэлээр хамтран ажиллав.
4. Нийгэмлэгийн үйл ажиллагааны тайланг „Төрийн бус байгууллагын тухай хууль”-ийн дагуу Улсын Бүртгэлийн Газарт дараа оны 2-р сарын 15-ны дотор албан ёсоор гарган өгч ажилласан ба татвар, нийгмийн даатгалын төлбөр, тооцоо, тайланг хуулийн хугацаанд хэрэгжүүлж ирлээ.
5. Гагнуурын мэргэжлийн ажиллагсад бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр төрийн байгууллагатай хамтран ажиллах зорилго бүхий Гагнуурын мэргэжлийн зөвлөлийг эрчим хүч, уул уурхай, төмөр зам, газрын тос, мэргэжлийн сургалт үйлдвэрлэл зэрэг байгууллагын төлөөлөл оролцуулсан 8 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж Мэргэжлийн Боловсрол Сургалтын Үнэлгээ Мэдээлэл Арга Зүйн Төвийн даргын А/120 тоот тушаалаар баталгаажууллаа.
6. Монголд анх удаа мэргэжлийн Гагнуур сэтгүүл бий болгох ажлыг ММСГН, ХБНГУ-ын GIZ хамтран зохион байгуулж, эхний дугаарыг амжилттай хэвлэн гаргав.
7. Гагнуурын форумын өмнө болон уг арга хэмжээний үеэр TV, сошиалаар нийгэмлэгийн сурталчилгаанууд хийгдсэнээс гадна УЗ-ийн гишүүн С.Батсайханы гагнуурын салбарын өмнө тулгарсан асуудлыг хөндсөн нийтлэл „Өдрийн сонин”-д хэвлүүлэх ажлыг ХБНГУ-ын ОУ-ын Хөгжлийн Агентлагийн туслалцаатай зохион байгуулсан. Төслийн нэгжтэй хамтран гагнуурын мэргэжил нийгэмлэгийг сурталчилсан дараах мэдээлэл контент бэлдэж сошиал телевизүүдээр цацсан. Үүнд:
  1. „Гагнуурчин Х.Тэгш-Амгалан” Өмнөговь ПК гагнуурчин. Эмэгтэй. Хувиараа ажиллагч 05:50 минут. МҮОНРТВ, ЭКО ТВ, facebook page, youtube суваг дээр байрлуулсан.
  2. „Гагнуурын форумын өмнөх мэдээлэл” GIZ-ийн төслийн ахлагч Бэата Диппмар, ММСГН г/з Н.Мягмарсүрэн, Хасу-Мегаватт ө/з Ж.Түмэн-Аюуш нарын ярилцлага 05:59 минут. МҮОНРТВ, ЭКО ТВ, facebook page, youtube суваг дээр байршуулсан.

3. „Гагнуурын форум” 04:06 минут. facebook page,youtube суваг дээр байрлуулсан. „МҮОНРТВ-ийн зочны ярилцлага” ГММСҮТөв сурагч М.Урангоо 10:06 минут. facebook page,youtube суваг дээр байрлуулсан.
8. Гагнуурын форум дээр „ММСГН-ийн үйл ажиллагаа цаашдын чиглэл” сэдвээр нийгэмлэгийн гүйцэтгэх захирал мэдээлэл хийсэн.
9. ММСГН-ийн гүйцэтгэх захирал 2020 оны 9-р сарын 3-нд Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, 9-р сарын 10-нд ХНХамгааллын сайд А.Ариунзаяа нартай хийсэн уулзалтуудад оролцож нийгэмлэгийн үйл ажиллагааны талаар танилцуулав.
10. Өмнөговь аймгийн Даланзадгад хотод болсон мэргэжлийн тэмцээний үеэр зохион байгуулагдсан ажил олгогч сургалтын байгууллага төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааны чөлөөт ярилцлагад гүйцэтгэх захирал оролцож нийгэмлэгийнхээ талаар танилцуулга хийсэн.
11. Улсын хэмжээнд зохион байгуулагдаж буй ААН,ТББ уудыг бүртгэлжүүлэх ажилд нийгэмлэгийг хамрууллаа

Б. Атестатчлал, сургалт, стандартын чиглэлээр

12. Эрдэс баялаг эрчим хүчний сайдын 2010 оны 01 сарын 25-ны өдрийн 21 тоот тушаалаар батлагдсан „Гагнуурчид болон гагнуурын инженер техникийн ажилтныг мэргэшүүлж зэрэг олгох дүрэм”-ийн дагуу Оюутолгой ХК, Хасу-Мегаватт ХХК, MCS ХХК, GSR ХХК, ДБЭХС ТӨХК, ДСМ ХХК, Багануур ХК зэрэг 16 үйлдвэр аж ахуйн нэгжүүдийн 290 мэргэшсэн гагнуурчин болон ГММСҮТөвийн 120 гагнуурчдаас мэргэжлийн шалгалт авч гэрчилгээ олгосон сунгасан байна .ММСГН Оюутолгой ХК-аас зарласан сонгон шалгаруулалтад оролцож шалгаран тус байгууллагын 80 гагнуурчинд атестатчлал хийсэн.
13. Нийгэмлэгээс Монгол улсын Засгийн газартай хамтран хэрэгжүүлж буй ХБНГУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн „Түншлэлд суурилсан мэргэжлийн боловсрол сургалтыг хөгжүүлэх нь” төсөл болон МАОЭНХолбоо хооронд байгуулсан гэрээний дагуу „Цахилгаан гар нуман гагнуурын мэргэжлийн лавлах /стандарт/” шинээр боловсруулж МБСҮЗөвлөлөөр батлууллаа. Лавлах /стандарт/-ыг веб сайтаас үзэж болно.
14. Тус онд ИШТХҮ ХХК, Зэт Эм ХХК, ДСМ ХХК компаниудын 11 гагнуурын инженер техникийн ажилтнуудад 2 өдрийн „Гагнуурын оёдлын гадна, дотоод гэмтэл согогийг судлах сургалт” зохион байгуулж сертификат олгосон.
15. Өмнөговь аймгийн Даланзадгадад болсон тэмцээний үеэр **гагнуурын багш, ажилтнуудад УЗ-ийн гишүүн С.Батсайхан ДУЧТэмцээний дүрэм, модуль, даалгаврын талаар хичээл заасан.**
16. ХБНГУ-ын оролцоотойгоор хийгдэж буй „Гагнуурын салбар дахь стратегийн түншлэл” төслийн хүрээнд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн гагнуурын чиглэлийн 6 стандартыг герман хэлнээс орчуулах ажил хийгдсэн. Германы Олон улсын хөгжлийн агентлагийн хүсэлтийн дагуу дээрх стандартуудыг мэргэжлийн зүгээс хянах, найруулга, үг хэллэг, нэр томьёог зүгшрүүлэх,оновчтой болгон засах зэрэг томоохон ажлыг нийгэмлэгийн зүгээс хийж гүйцэтгэв. Уг ажлын хүрээнд уул уурхай, эрчим хүч, төмөр зам, нисэх, газрын тос, МУИС, ТИС, ХААИС зэрэг байгууллагуудын гагнуурын зөвлөх инженер, эрдэмтэн, докторууд оролцсон өргөн хүрээний мэргэжлийн хэлэлцүүлгийг ГММСҮТөв дээр 4 удаа ажлын бус цагаар зохион байгуулж,

санал бодол, шүүмжүүдийг хүлээн авч орчуулгын стандартуудад тусгалаа. Хэлэлцүүлгүүдэд давхардсан тоогоор нийт 84 хүн оролцжээ.

17. Гагнуурын чиглэлийн 6 стандартыг мэргэжлийн чиглэлээр эцэслэн хэлэлцэх „Гагнуурын форум” хэлэлцүүлгийг 2020 оны 10-р сарын 30-нд Holiday Inn UB зочид буудалд ММСГН, GIZ хамтран амжилттай зохион байгуулав. Форумд ММСГН, GIZ-ээс гадна ХНХЯам, Стандартчлал Хэмжил зүйн газар, МХЕГазар, МБСҮАЗТөв, Эрчим хүчний хөгжлийн төв, ШУТИС, ХААИС, МУИС, Эрдэнэт ТС, МИАТ, Газрын тос, НИК, Төмөр зам, Үл эвдэх сорилын нийгэмлэг, Хасу-Мегаватт ХХК, ЗМ ХХК, ДЦС-3,4ТӨХК, Эрчим хүчний ассоциаци, Эрчим хүчний инженерүүдийн холбоо, ГММСҮТ, Техникийн коллеж зэрэг байгууллагуудын төлөөлөл оролцон стандартуудыг дэмжиж 2021 онд СХЗГ-ын хурлаар оруулж үндэсний стандартаар батлуулах зөвлөмж гаргасан.
18. МБСҮМАЗТ-тэй хамтран үнэлгээ, баталгаажуултын чиглэлээр 3 хүн сургалтанд хамруулж гэрчилгээжүүлсэн.

## В. Мэргэжлийн уралдаан тэмцээний чиглэлээр

19. ХНХЯам, МБСҮМАЗТ, GIZ-тэй хамтран гагнуураар суралцагсдын дунд „Монгол ур чадвар-2020” эхний шатлалын тэмцээний Өмнөговь аймгийн Даланзадгад хотод 2020 оны 10-р сарын 8-9 өдрүүдэд амжилттай зохион байгууллаа. Тус нийгэмлэгээс 4 дэх удаагаа зохион байгуулж буй дээрх тэмцээнд төрийн болон хувийн хэвшлийн 16 МСҮТ, коллежууд шилдгүүдээ оролцуулав. Тэмцээний шүүгчдийн бүрэлдэхүүнийг Сан –Паоло, Абу-Даби, Казаний Дэлхийн ур чадварын тэмцээнд оролцогсдоос Үнэлгээний төвийн сургалтанд хамруулж гэрчилгээжүүлсэн/ бүрдүүлж явууллаа. Тэмцээний дүнгээр Техник технологийн политехник коллежийн оюутан Б.Гантогтох 13.8 оноогоор тэргүүн байр, ГММСҮТөвийн Г.Отгонцэцэг 10.4 оноогоор 2-р байр, Өмнөговь аймгийн Ханбогд сумын Skills tech МСҮТ-ийн М.Энх-Амгалан 7.6 оноогоор 3-р байр тус тус эзэлсэн.

20. Нийгэмлэгээс БНХАУ-д зохион байгуулагддаг ARC CUP 2020 гагнуурчдын олон улсын тэмцээнд Монголын багийг оролцуулах ажлыг 5 дахь удаагаа зохион байгууллаа. Энэ жилийн тэмцээн цахим хэлбэрээр явагдаж Болгар, Унгар, Энэтхэг, Камерун, Иран, Монгол зэрэг гадаадын 6 орон оролцсон.

Монголын 10 хүнтэй багийг 2019 оны улсын аваргын тэмцээний шилдгүүдээс бүрэлдүүлж урьдчилан 2 хоногийн бэлтгэл хийлгэлээ. Тэмцээнийг гадна үзлэгийн дүн, радиографикийн зураг зэргийг илгээж явцыг тасралтгүй бичлэг хийн шууд харьцах зэргээр явуулсан. Тэмцээний дүн гарахад Цахилгаан гагнуурын төрөлд: Х.Бямбажав /MCS ХХК/ 1-р байр, Б.Оргил /ДЦС-4 ТӨХК/ 2-р байр, Аргон гагнуурын төрөлд: Э.Төмөрсүх /GCR ХХК/ 2-р байр эзэлсэн болохыг БНХАУ-ын талаас албан ёсоор мэдэгдсэн.

Тайлан бичсэн:



Н.Мягмарсүрэн